



“ТЭНГЭР ДААТГАЛ” ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ Б.БАЯНМӨНХ ТАНАА

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,  
E-mail: [info@frc.mn](mailto:info@frc.mn), <http://www.frc.mn>

2025.04.14 № 6/1360 .

Даатгалын бүтээгдэхүүнийг  
цахим хуудсанд байршуулсан тухай

“Тэнгэр даатгал” ХХК-аас 2025 оны 25/238 дугаар албан бичгээр ирүүлсэн “Барилга угсралтын даатгал”-ын бүтээгдэхүүний мэдээлэл, баримт бичгийг Даатгалын тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн дагуу хүлээн авч танилцлаа.

Тус компанийн “Барилга угсралтын даатгал”-ын бүтээгдэхүүн нь дээрх хууль, журмын шаардлагыг хангасан байх тул “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 6.1.16-д “Даатгагч нь даатгалын хэлбэр, бүтээгдэхүүнийг шинээр болон шинэчлэн зах зээлд борлуулахаас өмнө тухай бүр энэ журмын 4 дүгээр хавсралтад заасан мэдээллийг Хороонд ирүүлэх ба тус мэдээллийг Хороо өөрийн цахим хуудсанд байршуулна” гэж заасны дагуу Хорооны цахим хуудсанд байршуулав.



**Даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл**

12	Мэдэгдэл огноо	Он	2025	Сар	03	Өдөр	28
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	“Тэнгэр даатгал” ХХК					
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	“Барилга угсралтын даатгал”					
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Барилга угсралтын даатгал					
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр		Огноо	Дугаар		
		Даатгалын бүтээгдэхүүн шинээр батлах тухай		2025.03.28	А/17		
6	Цахимаар борлуулах эсэх	<input type="checkbox"/> Тийм <input checked="" type="checkbox"/> Үгүй					
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог		Нэр			
		Очирбат		Батжаргал			
<b>Мэдээллийн төрлийг сонгоно уу.</b>							
8	<input checked="" type="checkbox"/> Даатгалын бүтээгдэхүүнийг шинээр борлуулах <input type="checkbox"/> Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх <input type="checkbox"/> Даатгалын бүтээгдэхүүнийг банк даатгалын зуучлагчаар дамжуулан зуучлан борлуулах						
<b>Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл</b>							
	Даатгалын зүйл	1. Даатгуулагчийн үндсэн болон гэрээт гүйцэтгэгчийн барьж байгуулж буй ... хаягт орших барилга угсралтын ... ажлын талбайд буй дараах хөрөнгө байна. Үүнд: 1.1. Барьж байгуулж буй барилга, байгууламж; 1.2. Барилгын бараа материал; 1.3. Тоног төхөөрөмж; 1.4. Машин механизм; 1.5. Тээврийн хэрэгсэл; 1.6. Ажилчдын түр орон сууц, оффис, агуулах. 2. Даатгуулагчийн энэхүү гэрээнд тусгагдсан хаягт барилга угсралтын ажил гүйцэтгэх явцад ажлын талбай орчмын ... метрийн радиус дахь гуравдагч этгээдийн өмнө хүлээх хуулийн хариуцлага байна.					
	Даатгалын үндсэн эрсдэл	1. Галын эрсдэл; 2. Байгалийн эрсдэл; 3. Тээврийн хэрэгсэл, машин механизмд учрах эрсдэл; 4. Даатгуулагчийн барилга угсралтын ажил гүйцэтгэх явцад ажлын талбай орчмын ... метрийн радиус дахь гуравдагч этгээдийн эд хөрөнгө, амь нас, эрүүл мэндийн өмнө хүлээх хуулийн хариуцлага.					
	Даатгалын нэмэлт эрсдэл	Даатгуулагчтай тохиролцоно					
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	0.3%-0.6%*					

		*-Даатгуулагчийн бизнесийн онцлог, ажил үйлчилгээний төрөл, хариуцлагын хэмжээ, даатгалын үнэлгээ, даатгалын эрсдэлийн түвшингээс хамааран даатгалын хураамж нь өсөх, буурах боломжтой.
	Даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ	20%-25%